

ТАНИЛЦУУЛГА

“Сэтгэцийн шинжилгээ
хийх журам”-ын талаар

Шүүх шинжилгээний тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8-д “Шүүх сэтгэцийн шинжилгээ хийх журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасны дагуу эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад сэтгэцийн шинжилгээ хийх харилцааг зохицуулахаар шинээр боловсруулсан.

Сэтгэцийн шинжилгээ хийхэд Шүүх шинжилгээний тухай хууль, холбогдох стандарт, дүрэм, заавар болон энэхүү журмыг удирдлага болгоно.

Сэтгэцийн шинжилгээ хийх эрх зүйн орчныг нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох ажлын хүрээнд тус журмын төсөлд шинэ төрлийн шинжилгээний шаардлагыг харгалзан дараах зохицуулалтыг найруулан тусгасан:

- шинжилгээ хийх нийтлэг үндэслэл, баримтлах хууль тогтоомж, зарчим;
- шинжилгээ хийхэд тавигдах нийтлэг шаардлага;
- сэтгэцийн шинжилгээ хийх шинжээч эмчийн эрх, үүрэг;
- сэтгэцийн шинжилгээний хэлбэр;
- иргэний хэрэгт сэтгэцийн шинжилгээ хийх;
- сэтгэцийн шинжилгээний зардал болон хариуцлага зэрэг болно.

Журмын төсөл батлагдсанаар “Шүүх шинжилгээний тухай” хуулийн шинэчилсэн найруулгын 39 дүгээр зүйл хэрэгжих эрх зүйн зохицуулалт бий болох бөгөөд шүүх сэтгэцийн шинжилгээний онцлогт тулгуурласан шинжилгээ хийх үйл ажиллагаа сайжирч, шинжээчийн дүгнэлт хэрэг маргааныг шийдвэрлэхэд чухал ач холбогдол бүхий нотлох баримтын эх сурвалж болох хууль эрх зүйн үндэслэл бүрдэх юм.

---oOo---